

**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ  
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН 2017 ОНЫ 8 ДУГААР ХУРАЛДААН**

Хуралдаан 2017 оны тавдугаар сарын 17-ны 15 цаг 10 минутад эхэлж, 16 цаг 16 минут хүртэл Засаг даргын Тамгын газрын даргын өрөөнд болж, нийт 1 цаг 06 минут үргэлжлэв.

№	Хэлэлцэх асуудлын төлөвлөгөө	Шийдвэр
1	Цагаандэлгэр сумын ЗДТГ-ын Санхүүгийн албаны дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч, Уламжлалт анагаах ухааны төвийн дарга, Зоонозын өвчин судлалын төвийн дарга, Гурвансайхан, Цагаандэлгэр, Говь-Угтаал сумын Эрүүл мэндийн төвийн дарга, Цагаандэлгэр сумын Соёлын төвийн эрхлэгчийн албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтын дүнгийн тухай	Цагаандэлгэр сумын Засаг даргын Тамгын газрын Санхүүгийн албаны дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогчийн албан тушаалд Ёндондорж овогтой Мядагмаа, Уламжлалт анагаах ухааны төвийн даргын албан Хүдэрчулуун овогтой Чирчинсүрэнг нэр дэвшүүлсэн тогтоол гаргаж, холбогдох байгууллагуудад хүргүүлэх
2	Дундговь аймгийн нутгийн захиргааны байгууллагуудын захиалгын дагуу төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөөцөөс нөхөх тухай -Нөөцийн зард бүртгүүлсэн иргэдийг нэр дэвшүүлэх -Өлзийт сумын Засаг даргын Тамгын газрын Төрийн сангийн мэргэжилтний албан тушаалд нөөцөөс нэр дэвшүүлэх - Эрүүл мэндийн газрын Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар эрсдэл, оношлогоо эмчилгээний технологи хариуцсан мэргэжилтний сул орон тоог нөөцөөс нэр дэвшүүлэх -Хүнс, хөдөө аж ахуйн газрын Хүний нөөц, сургалт, тайлан мэдээ хариуцсан мэргэжилтний сул орон тоонд нөөцөөс нэр дэвшүүлэх -Дэлгэрцогт сумын ЗДТГ-ын төрийн сангийн мэргэжилтний албан тушаалд нэр дэвшүүлэх асуудлыг дахин хэлэлцэх тухай	Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтсийн Гурвансайхан сум хариуцсан нийгмийн даатгалын байцаагчийн албан тушаалд Цэгмэд овогтой Сосорбурамыг, Өлзийт сумын Засаг даргын Тамгын газрын төрийн сангийн мэргэжилтний албан тушаалд Бадамсүрэн овогтой Гарамхандыг, Эрүүл мэндийн газрын Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар эрсдэл, оношлогоо эмчилгээний технологи хариуцсан мэргэжилтний албан тушаалд Лхүндэвпэрэнлэй овогтой Ганбатыг, Хүнс, хөдөө аж ахуйн газрын Хүний нөөц, сургалт, тайлан мэдээ хариуцсан мэргэжилтний албан тушаалд Лхагва овогтой Нарантуяаг тус тус нэр дэвшүүлсэн тогтоол гаргаж холбогдох байгууллагуудад хүргүүлэх. Гурвансайхан сумын ЗДТГ-ын МЭҮТ-ийн мэргэжилтний албан тушаалд бүртгүүлсэн Б.Батмөнхийг тухайн байгууллага нь авч ажиллуулах саналаа ирүүлсэн тохиодолд нэр дэвшүүлэх хариу өгөхөөр шийдвэрлэв. Дэлгэрцогт сумын Төрийн сангийн мэргэжилтний албан тушаалд нэр дэвшүүлсэн Б.Баатарсүрэнг томилон ажиллуулахаас татгалзсан нь хууль эрх зүйн үндэслэлгүй гэж үзлээ.
3	Дундговь аймгийн нутгийн захиргааны байгууллагуудын захиалгын дагуу төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоонд мэргэшлийн шалгалт зарлуулах тухай	Дундговь аймгийн нутгийн захиргааны байгууллагуудын захиалгын дагуу төрийн жинхэнэ албан тушаалын 10 сул орон тоонд мэргэшлийн шалгалт зарлуулахаар ТАЗ-д хүргүүлэхээр шийдвэрлэв.
4	Эрдэнэдалай, Цагаандэлгэр, Гурвансайхан сумдын ИТХ-ын нарийн бичгийн дарга, аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн дарга, Гурвансайхан, Цагаандэлгэр, Говь-Угтаал сумын Эрүүл мэндийн төвийн дарга, Цагаандэлгэр сумын Соёлын төвийн эрхлэгчийн албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалт зарлах тухай	Эрдэнэдалай, Цагаандэлгэр, Гурвансайхан сумдын ИТХ-ын нарийн бичгийн дарга, аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн дарга, Гурвансайхан, Цагаандэлгэр, Говь-Угтаал сумын Эрүүл мэндийн төвийн дарга, Цагаандэлгэр сумын Соёлын төвийн эрхлэгчийн албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтыг зарлаж, бүртгэлийг 2017 оны 06 сарын 14-ний өдөр, шалгалтыг 06 сарын 15-16-ны өдөр зохион байгуулахаар шийдвэрлэв.